

## ХАВСРАЛТ: НҮБ-ын Авилгалын эсрэг конвенц (АЭК)-ын хэрэгжилтийн тайлан:

**52-р зүйл: Гэмт хэргээс олсон ашиг орлогыг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, шилжүүлгийг илрүүлэх**

### **52-р зүйлийн 1-р бүлэг**

Энэхүү конвенцийн 14 дүгээр зүйлийг үл хөндөн оролцогч улс бүр өөрийн харьяалалд багтах санхүүгийн байгууллагуудаас харилцагчдийн биеийн байцаалтыг нягталж тодорхойлох, өндөр дүнтэй дансны эцсийн өмчлөгч хэн болохыг тодорхойлох талаар боломжит арга хэмжээ авах болон төрийн/нийтийн албаны өндөр ажил үүрэг гүйцэтгэж байгаа буюу өмнө байсан хувь хүн, тэдний гэр бүлийн гишүүд болон ойр дотны түншүүдийн нээх гэсэн буюу эзэмшиж буй данс, эсхүл нэрийн өмнөөс нээх гэсэн буюу эзэмшиж буй дансанд хатуу хяналт явуулахыг шаардахад шаардлагатай байж болох арга хэмжээг дотоодын хууль тогтоомжид нийцүүлэн авна. Уг нэмэгдүүлсэн, хатуу хяналт нь сэжигтэй гүйлгээг эрх бүхий байгууллагад мэдээлэх зорилгоор илрүүлэхэд зориулагдсан байх бөгөөд санхүүгийн байгууллагыг хууль ёсны харилцагчтай бизнесийн үйл ажиллагаа явуулахыг саатуулсан буюу хориглох гэсэн утгаар ойлгогдож болохгүй.

#### **1. Танай улсад уг зүйл заалтыг мөрддөг үү?**

**ХАРИУЛТ:** Гийм

#### **2. Уг зүйлийг хэрэгжүүлэх тал дээр танай улс ямар арга хэмжээ авч байгааг тодорхойлно уу. (иш татан, нэгтгэн дүгнэх)**

**ХАРИУЛТ:**

Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2011 оны 156/45 дугаар тушаалаар батлагдсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд хяналт шалгалт хийх журам” болон Санхүүгийн зохицуулах хорооноос 2009 оны 253 дугаар тогтоолоор батлагдсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчаа таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам” зэрэг нэмэлт журмуудыг Хөрөнгө оруулалтын сан, Банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж зээлийн хоршоод, Даатгалын болон Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зохицуулалттай этгээд (Үнэт цаасны компани, кастодианы үйлчилгээ үзүүлэгч банк, үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх аудитор, мэргэшсэн нягтлан бодогч, үнэлгээчин болон хуульч гэх мэт) мөрдөн ажиллаж байна.

- Мөн Хорооноос Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 312 дугаар тушаалаар батлагдсан “МУТС-ээс сэргийлэх, түүнтэй тэмцэхэд харилцагчийг таньж мэдэх талаар банкны баримтлах журам”-ыг шинэчлэн найруулахтай холбогдуулан Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанаас ОУВС-аас туслалцаа авч боловсруулсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа”-ны журмын төсөлд санал хүргүүлсэн.

Тухайлбал: Дээрх журмын төслийг 2013 онд шинэчлэн батлагдсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хууль болон 2012 онд ФАТФ-аас олон улсын стандарт болгон гаргасан МУТС-ээс сэргийлэх 40 зөвлөмжид үндэслэн боловсруулсан тул зарчмын хувьд ялгаатай байр суурь, саналгүй боловч цаашид дараах асуудлыг анхаарах нь зүйтэй гэж үзсэн.

1/ Олон улсад хөрөнгө оруулагчдыг хамгаалах, зах зээлийн шудрага, үр ашигтай, ил тод байдлыг хангах, үнэт цаасны зах зээлийг МУТС-ээс сэргийлэх хамгийн чухал үйл ажиллагаа нь харилцагчийг таньж мэдэх (CDD), эцсийн өмчлөгчийг тодруулах үйл ажиллагаа байдаг бөгөөд манай улсын санхүүгийн зах зээлд Кастодиан банк, Хөрөнгө оруулалтын менежментийн компани, хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын сан зэрэг шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх байгууллагууд үйл ажиллагаа явуулж эхэлсэнтэй холбоотойгоор энэ салбаруудад орж ирж байгаа хөрөнгө оруулалтын зорилго, бизнесийн нөхцөл байдлыг тодорхойлох, эцсийн өмчлөгчийг олж тогтоох (ялангуяа олон этгээдийн данс (omnibus account) үйл ажиллагаанд онцгой ач холбогдол өгөх;

2/ “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн 19.1-д заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо нь банк, нотариатаас бусад мэдүүлэх үүрэгтэй этгээдэд хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг Санхүүгийн мэдээллийн албатай хамтран хэрэгжүүлэх учраас хоёр байгууллагын хооронд мэдээлэл солилцох сувгийг бий болгох, мэдээлэх боломжоор хангах асуудлыг тусгах.

- Мөнгө угаах эрсдлийг багасгах/бууруулах зорилгоор санхүүгийн байгууллагууд, зохих тохиолдолд бусад аж ахуйн нэгж, хуулийн этгээдүүдийг өөрсдийн харилцагчийг магадлан шалгалт, бүртгэл зэрэг бусад урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрсдэлд суурилсан зарчмаар мөрдөж байх шаардлагыг Хорооны 2015 оны 406 дугаар тогтоолоор “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх журам”-аар батласан.
- Хуулийн этгээд болон хуулийн зохицуулалт бүхий эзэмшил нэрийн дор эзэмшиж буй данс, дансан дах мөнгөн хөрөнгийн эцсийн өмчлөгчийн биеийн байцаалтыг тодорхойлох, баталгаажуулах магадлан хяналт шалгалтын тодорхой заалт шаардлагад Хөрөнгө оруулалтын сан болон Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зохицуулалттай этгээд нь харилцагчийн магадлан хөндлөнгийн хяналт шалгалт хийлгэх шаардлагатай. Энэ нь Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д заасан этгээдүүд нь мөн хуулийн 7 дугаар зүйлд заасан гүйлгээний талаарх мэдээллийг мөн хуулийн 16.1-д заасан Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй байдаг бөгөөд тус хуулийн 5.1-д заасан харилцагчийг албан ёсны эх сурвалж, баримт бичиг, мэдээ, мэдээллийн эх үүсвэр ашиглан таньж мэдэх үүрэгтэй.

Бичил санхүүгийн зохицуулалтын хүрээнд: Хороонд харьяалагдах мэдээлэх үүрэгтэй этгээд гэж Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журмын 1.2.1-д болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д зааснаар:

1.2.1.1. Банк бус санхүүгийн байгууллага;

1.2.1.4. Хадгаламж, зээлийн хоршоог зааж өгсөн.

-Мөнгө угаах эрсдэлийг багасгах / бууруулах зорилгоор санхүүгийн байгууллагууд, зохих тохиолдолд бусад аж ахуйн нэгж, хуулийн этгээдүүдийг өөрсдийн харилцагчийн магадлан шалгалт, бүртгэл зэрэг бусад урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрсдэлд суурилсан зарчмаар мөрдөж байх шаардлагыг Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам, заавар, Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохицуулалтын журам, заавраар баталсан.

-ББСБ, ХЗХ-дод харилцагчийн магадлан хөндлөнгийн хяналт шалгалт хийлгэх шаардлагатай.

-Хуулийн этгээд болон хуулийн зохицуулалт бүхий эзэмшил нэрийн дор эзэмшиж буй данс, дансан дах мөнгөн хөрөнгийн эцсийн өмчлөгчийн биеийн байцаалтыг тодорхойлох, баталгаажуулах заалт шаардлагыг журмын 2 дугаар зүйлд тусгасан. Үүнд :

2.1. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчийг таньж мэдэх зорилгоор Хорооноос зөвшөөрөгдсөн үйлчилгээ үзүүлэхийн өмнө дараахь мэдээллийг харилцагчаас гаргуулж авна:

2.1.1. Харилцагч нь иргэн бол түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа хаяг, регистрийн дугаар, холбоо барих утасны дугаар,

2.1.2. Харилцагч нь хуулийн этгээд бол түүний нэр, албан ёсны хаяг, улсын бүртгэлийн болон татвар төлөгчийн дугаар, харилцах утасны дугаар, төлөөлөн үйл ажиллагаа явуулах эрх бүхий этгээдийн нэр, хаяг,

2.1.3. Мэдээлэх үүрэгтэй этгээд харилцах, хадгаламж, гишүүнчлэл эсхүл зээлийн данс нээсэн, гэрээ байгуулсан этгээд нь иргэн бол түүний иргэний үнэмлэхний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, хуулийн этгээд бол түүний улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, хувь нийлүүлэгч, удирдлагын талаарх дэлгэрэнгүй танилцуулга,

2.1.4. Гүйлгээний утга, хийгдсэн гэрээ, хүлээн авагчийн тухай мэдээлэл,

2.1.5. Бусдын өмнөөс гүйлгээ хийж байгаа тохиолдолд төлөөлүүлж байгаа этгээдийн талаарх мэдээлэл;

2.1.6. Бэлэн бус шилжүүлэг хийсэн этгээдийн тухай мэдээлэл.

-Өндөр дүнтэй дансийг хянахтай холбоотой шаардлагуудыг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д заасан этгээдүүд нь мөн хуулийн 7 дугаар зүйлд заасан гүйлгээний талаарх мэдээллийг мөн хуулийн 16.1-д заасан Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй байдаг бөгөөд тус хуулийн 5.1-д заасан харилцагчийг албан ёсны эх сурвалж, баримт бичиг, мэдээ, мэдээллийн эх үүсвэр ашиглан таньж мэдэх үүрэгтэй байхаар тусгасан.

-Төрийн/нийтийн өндөр албан тушаал хашиж буй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд болон ойр дотны түншүүдийн хувьд (нийтэд нь ТӨАТ/PEPs); PEPs-ийг тодорхойлох тогтолцоо байхгүй.

-PEPs болон тэдний нэрийн өмнөөс эзэмшиж буй дансуудыг магадлан шалгах, хатуу хяналт тавих шаардлага байхгүй.

-Дотоодын болон гадаад улсын PEPs/ТӨАТ-ыг тусад нь авч үздэггүй, тус бүрт хэрэгжүүлж буй арга хэмжээ байхгүй.

**Даатгалын зохицуулалтын хүрээнд:**Хороо нь эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх хүрээнд Даатгалын байгууллагад хийх хяналт шалгалтын аргачлал болон даатгалын компаниуд өөрсдөө эрсдлээ тооцох тайлагналын зарчмыг МОН-004 төсөл болон олон улсын зөвлөхүүдтэй хамтран хэрэгжүүлж байна. Энэ ажлын хүрээнд мөнгө угаах эрсдлийг багасгах/бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах зэрэг заалтуудыг тусгахаар ажиллаж байна. Одоогийн байдлаар эцэслэгдэж гараагүй болно.

-Хорооны 2015 оны 407 дугаар тогтоолоор батлагдсан Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл бүртгэлийн журмын 1, 3, 5-д заасан болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1-д зааснаар дотоод хяналтын хөтөлбөр боловсруулан мөрдөж ажиллах, 5.1.2-д дүрмийн санд оруулсан хөрөнгө нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой сэжиг бүхий гэж үзвэл Хороо нэмэлт мэдээлэл шаардаж болно гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Түүнчлэн Хорооны 2010 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-ыг шинэчилэн баталснаар нэр дэвшигчийн биеийн байцаалтыг нягталж тодорхойлох, дансны эцсийн өмчлөгч хэн болохыг тодорхойлох, төрийн /нийтийн албанд ажил үүрэг гүйцэтгэж байгаа буюу өмнө байсан тодорхойлох замаар хяналт явуулахыг шаардахад шаардлагатай байж болох арга хэмжээг дотоодын хууль тогтоомжид нийцүүлэн авч байна.

-Хяналт шалгалтын газар дээрх хяналтыг хэрэгжүүлж байгаа тохиолдолд өндөр дүнтэй дансны эцсийн өмчлөгч хэн болохыг тодорхойлох, санхүүгийн байгууллагын хууль ёсны бизнес, тэдний түншүүдийн эзэмшиж буй дансанд хяналт явуулахыг шаардахад шаардлагатай байж болох арга хэмжээг дотоодын хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлж байна.

-Монголбанкны зээлийн мэдээллийн сантай харилцан хамтран ажиллаж байна.

-Олон улсын даатгалын хянан шалгагчдын холбооны гишүүнээр элсэн тив дамнасан хяналт, хамтын ажиллагааны санамж бичигт элсэхээр бэлдэж байгаа болно.

### 3. Тухайн хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар жишээ татна уу.

#### ХАРИУЛТ:

Уг зүйл заалтыг бодитоор практикт хэрэгжүүлхээр гүйцэтгэсэн арга хэмжээнд:

- Үнэт цаасны зохицуулалтын хүрээнд: Хорооноос тусгай зөвшөөрөл олгоход Хорооны 2015 оны 406 дугаар тогтоолоор “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх журам”-аар тусгай зөвшөөрөл хүсэгч этгээдүүд дотооддоо мөрдүүлж хэвшүүлэхээр батласан тухайн байгууллагын “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжүүлэх журам”-ыг шаарддаг болсон. Ингэснээр шинээр тусгай зөвшөөрөл хүсэгч нь мэдээлэх үүргээ хэрэгжүүлэх хяналт, зохицуулалтыг өөрсдөө хэрэгжүүлэх боломжтой болж байна.

Тухайлбал: Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч тусгай зөвшөөрөл хүсэгч болон авсан зохицуулалттай этгээдүүд зохих тохиолдолд харилцагчийн магадлан дараах зүйлсийг өөрсдийн дотооддоо мөрдөж ажилладаг байхыг дотоод журамдаа тусгаж, нэвтрүүлэх боломжтой болсон. Үүнд: харилцагчаа таних, сэжигтэй гүйлгээний талаар мэдээлэх, баримт хадгалах, дотоод хяналт, өндөр дүнтэй дансийг хянахтай холбоотой шаардлагууд, компаний эцсийн өмчлөгчийг таних, шалгах, тохиромжтой этгээдийг тодорхойлох, их хэмжээний хэлцэл хийсэн талаарх мэдээлэл, хувийн ашиг сонирхолын зөрчлийг тодорхойлох, хяналт шалгалт тавих зэрэг хуулийн хэрэгжилтийг хангах.

Мөн Хорооны 2015 оны 406 дугаар тогтоолоор “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх журам” батлагдсантай холбоотойгоор Зөвшөөрлийн цахим системийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн шинээр нэвтрүүлж, Хорооны хянан шалгагч нар мэдээллийн баазыг сайжруулах, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх боломжийг олгож байна.

Бичил санхүүгийн зохицуулалтын хүрээнд: Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд дотоод хяналтын хөтөлбөрийг баталж мөрдөх бөгөөд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод журмын хэрэгжилтийг хариуцах, байнгын хяналт тавих үүрэг бүхий ажилтныг томилж ажиллуулахаар тусгасан. Мөн Хороонд тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт ирүүлэхэд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журмын хасвралт (Маягт СЗХ02001), Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохицуулалтын журмын дагуу тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн хавсралт (Маягт СЗХ01001)-д Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1.2-т заасны дагуу хяналт тавих ажилтныг томилсон шийдвэрийг ирүүлэхээр тусгаж харилцагчийн нарийвчилсан магадлан шалгалт хийх, данс дансны гүйлгээг бүртгэх болон хяналт тавьж байхаар тусгасан. Ингэснээр шинээр тусгай зөвшөөрөл хүсэгч нь мэдээлэх үүргээ хэрэгжүүлэх хяналт, зохицуулалтыг өөрсдөө хэрэгжүүлэх боломжтой болж байна.

Тухайлбал: Тусгай зөвшөөрөл хүсэгч болон авсан ББСБ, ХЗХ-д тодорхой тохиолдолд харилцагчийн магадлан дараах зүйлсийг өөрсдийн дотооддоо мөрдөж ажилладаг байхыг дотоод журамдаа тусгаж, нэвтрүүлэх боломжтой болсон. Үүнд: харилцагчаа таних, сэжигтэй гүйлгээний талаар мэдээлэх, баримт хадгалах, дотоод хяналт, өндөр дүнтэй дансийг хянахтай холбоотой шаардлагууд, компаний эцсийн өмчлөгчийг таних, шалгах, тохиромжтой этгээдийг тодорхойлох, их хэмжээний хэлцэл хийсэн талаарх мэдээлэл, хувийн ашиг сонирхолын зөрчлийг тодорхойлох, хяналт шалгалт тавих зэрэг хуулийн хэрэгжилтийг хангах.

Даатгалын зохицуулалтын хүрээнд: Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх хүрээнд МОН-004 төслийн шугамаар олон улсын зөвлөх сургалт явуулсан, мөн цаашид даатгалын компаниуд өөрсдөө эрсдлээ тооцоох тайлагнах хүрээнд олон улсын зөвлөх ирж ажиллахаар байгаа болно.

Даатгалын байгууллагуудаас сар, улирал бүр ирүүлсэн тайланд зайны хяналт тавьж, тайлан гаргадаг. Мөнгө угаах эрсдэлтэй холбоотой сэжигтэй тоон мэдээлэл илэрсэн тохиолдолд хяналт шалгалтын тайланд сар бүр тусгагдаж, мэдээллэхээр байгаа.

Бүртгэл зөвшөөрлийн хүрээнд: Нэгдүгээрт: Зохицуулалтын хувьд: Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулиар олгогдсон эрхийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны чиг үүргийн дагуу тусгай зөвшөөрлийг анх олгох үед хүсэлт, түүнд хавсарган ирүүлэх баримт бичигт уг хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих ажилтан томилсон шийдвэр, тухайн ажилтаны анкет тодорхойлолтыг заавал бүрдүүлсэн байх шаардлагыг тавьж байна.

Хоёрдугаарт: Хяналтын хувьд: Уг хуулийн хэрэгжилтэд хяналтыг хэрэгжүүлэхдээ тусгай зөвшөөрөл олгогдсон зохицуулалтын байгууллагуудын хувьд тэдгээрийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалтын үед хяналт тавих ажилтан нь тухайн албан тушаалдаа байгаа эсэхийг нягтлан шалгахад гадна, газар дээрх үзлэг, шалгалт хийхдээ 20,0 сая төгрөг, түүнтэй тэнцэх хэмжээний валютын гүйлгээ гарсан эсэх, энэ тохиолдолд Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлсэн эсэхийг газар дээр нь баримт бичигтэй нь тулган шалгаж байна.

Сэжигтэй гүйлгээг мэдээлсэн эсэхээс гадна харилцагчийн нэр, хаяг тодорхойгүй гүйлгээ гарсан эсэхийг мөн нягтлан шалгаж байна. Хэрхэн хяналт тавих талаар журамд зохицуулсан бөгөөд хяналт шалгалт хийх удирдамжид зүйл, заалт болгон оруулсан байна.

## **52-р Зүйл, дэд бүлэг 2(а)**

Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлэхийг хөнгөвчлөхийн тулд оролцогч улс бүр дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэн, мөнгө угаахтай тэмцдэг бүс нутгийн, бүс хоорондын болон олон талт байгууллагуудын санаачлагыг удирдлага болгоно:

- (а) харьяалалд нь багтах санхүүгийн байгууллагаас дансанд нь хатуу хяналт явуулах ёстой хувь хүн, хуулийн этгээдийн төрөл, онцгой анхаарал хандуулах данс ба гүйлгээний төрөл, түүнчлэн тэдгээр данстай холбогдуулан данс нээх, эзэмших, бүртгэл хөтлөх талаархи зохих арга хэмжээний талаар сэрэмжлүүлэг заавар гаргаж;

### **1. Танай улсад уг зүйл заалтыг мөрддөг үү?**

**ХАРИУЛТ:** Гийм

### **2. АВИЛГАЛЫН ЭСРЭГ НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН КОНВЕНЦ-ын уг Зүйлийг хэрэгжүүлэх тал дээр танай улс ямар арга хэмжээ авч байгааг тодорхойлно уу. (иш татан, нэгтгэн дүгнэх)**

**ХАРИУЛТ:**

Санхүүгийн мэргэжлийн байгууллага, зохих тохиолдолд бусад хуулийн этгээдүүдэд хэзээ болон ямар тохиолдолд харилцагчийн нарийвчилсан магадлан шалгалт хийх, данс дансны гүйлгээг бүртгэх болон хяналт тавих, мөн түүнчлэн энгийн иргэд эсвэл хуулийн этгээд тэдгээрийн данс, дансны гүйлгээний төрөл зүйлд тохирох шаардлагат нөхцлүүдийг зааж өгсөн зөвлөмж, зөвлөгөөг Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанаас Санхүүгийн байгууллагуудад зайны хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар сургалт, зөвлөмж гаргасан бөгөөд уг зөвлөмжүүд дотоодын хууль тогтоомжтой нийцдэг гэж үзэж байна.

Тухайлбал: 2013 онд шинэчлэн батлагдсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хууль болон 2012 онд ФАТФ-аас олон улсын стандарт болгон гаргасан МУТС-ээс сэргийлэх 40 зөвлөмжид үндэслэн боловсруулсан.

[Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам](#)-ын дагуу дараах мэдээллийг СМА-д гаргаж, хүргүүлдэг. Үүнд:

- [Сэжигтэй гүйлгээний тайлан](#)
- [Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан](#)

Монгол улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2011 оны 156/45 дугаар тушаалаар батлагдсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд хяналт шалгалт хийх журам” болон Хорооноос 2009 оны 253 дугаар тогтоолоор батлагдсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчаа таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам” зэрэг нэмэлт журмуудыг мөнгө угаахтай тэмцдэг бүс нутгийн, бүс хоорондын болон олон талт байгууллагуудын удирдамжийг удиртгал болгон дотоодын хууль тогтоомжид тусгасан.

### **3. Тухайн хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар жишээ татна уу.**

#### **ХАРИУЛТ:**

Хороо нь мөнгө угаахтай тэмцдэг бүс нутгийн, бүс хоорондын болон олон талт байгууллагуудын болон бусад улсын хяналт, шалгалтын байгууллагуудтай хоёр талт хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна. Үнэт цаасны зах зээлийн хувьд:

- Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын талаар хамтран ажиллах тухай Хоёр талт санамж бичгийг 2008 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр үзэглэсэн.
- Санхүүгийн хяналт шалгалтын асуудлаар ижил тэгш, харилцан үр ашигтай байх Хоёр талт санамж бичгийг 2009 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр үзэглэсэн.
- Санхүүгийн хяналт шалгалтын хүрээнд харилцан хамтран ажиллах, туслалцаа үзүүлэх тухай Хоёр талт санамж бичгийг 2011 оны 09 дүгээр сарын 2-ны өдөр үзэглэсэн.
- Үнэт цаасны зах зээлийн зохицуулалт, хянан шалгалтын талаар хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох тухай /Санхүүгийн зах зээлийн зохицуулалт, санхүүгийн үйлчилгээнд хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, зах зээлийн зохистой байдлыг хангах/ Хоёр талт санамж бичгийг 2013 оны 10 дугаар сарын 11-ний өдөр үзэглэсэн.
- Үнэт цаасны зах зээлийн зохицуулалт, хянан шалгалтын талаар хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох тухай Хоёр талт санамж бичгийг 2014 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр үзэглэсэн.

-Даатгалын зохицуулалтын хувьд: Хорооны 2016 оны 105 дугаар тогтоолоор батлагдсан “Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам”, 2009 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Урт хугацааны даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”, 2011 оны 337 дугаар тогтоолоор баталсан “Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах” зэрэг журамд даатгагчийн банкны харилцах, хадгаламжид байршуулах хөрөнгийн хэмжээг тодорхой зааж хяналт тавина ажиллаж байна. Мөн Даатгалын нягтлан бодох бүртгэлийн дансны зааврыг шинэчилэн баталж, дансны бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэн тодорхой болгосон.

-Бичил санхүүгийн зохицуулалтын хувьд: Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1.-д ...мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын хөтөлбөр баталж, мөрдүүлэхээр заасан бөгөөд Хорооны Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журмын хасвралт (Маягт СЗХ02001), Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохицуулалтын журмын дагуу тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн хавсралт(Маягт СЗХ01001)-д хяналт

тавих ажилтныг томилсон шийдвэрийг ирүүлэхээр тусгасан ба харилцагчийн нарийвчилсан магадлан шалгалт хийх, данс дансны гүйлгээг бүртгэх болон хяналт тавих, мөн түүнчлэн энгийн иргэд эсвэл хуулийн этгээд тэдгээрийн данс, дансны гүйлгээний төрөл зүйлд тохирох шаардлагат нөхцлүүдийг тусгах талаар зөвлөгөө өгч байхаар журамласан.

### **52-р Зүйл, дэд бүлэг 2(б)**

Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлэх явдлыг хөнгөвчлөн дэмжихийн тулд оролцогч улс бүр дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэн, мөнгө угаахтай тэмцдэг бүс нутгийн, бүс хоорондын болон олон талт байгууллагуудын санаачлагыг удирдлага болгон:

(б) хуулийн харьяалалд нь багтах санхүүгийн байгууллага өөр журмаар таньж тогтоосон хувь хүн, хуулийн этгээдээс гадна эдгээр санхүүгийн байгууллагаас хатуу хяналт явуулах ёстой тодорхой хувь хүн, хуулийн этгээдийн талаар санхүүгийн эдгээр байгууллагад оролцогч өөр улсын хүсэлтээр эсхүл өөрийн санаачлагаар зохих тохиолдолд мэдэгдэнэ.

**1. Танай улсад уг зүйл заалтыг мөрддөг үү? -Тийм**

**2. АВИЛГАЛЫН ЭСРЭГ НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН КОНВЕНЦ-ын уг Зүйлийг хэрэгжүүлэх тал дээр танай улс ямар арга хэмжээ авч байгааг (эсвэл төлөвлөж байгаа арга хэмжээг) тодорхойлно уу. (иш татан, нэгтгэн дүгнэх)**

#### **Хариулт:**

Зохицуулалтын салбарын хуулиас гадна Хорооноос тэдгээр хуулиудад нийцүүлэн боловсруулсан зохицуулалтын журамд холбогдох хяналт зохицуулалтыг нарийвчлан зохицуулсан бөгөөд хууль, журмаар тогтоосон нөхцөл шаардлагыг хангаж байгаа эсэхэд зайнаас болон газар дээрх хяналт шалгалтыг тогтмол хийж байна.

#### **Хариулт:**

Салбарын зохицуулалтын байгууллагуудад эрсдэлийн үнэлгээг улирал бүр хийж байна. Мөн зохицуулалтын салбаруудын улирал, жилийн тоон мэдээллүүдийг нэгтгэн, зах зээлийн болон салбарын тойм, дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж, УИХ болон бусад төрийн байгууллагуудад тогтмол хүргүүлдэг.

### **52-р Зүйл, дэд бүлэг 2(б)**

Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлэх явдлыг хөнгөвчлөн дэмжихийн тулд оролцогч улс бүр дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэн, мөнгө угаахтай тэмцдэг бүс нутгийн, бүс хоорондын болон олон талт байгууллагуудын санаачлагыг удирдлага болгон:

(б) хуулийн харьяалалд нь багтах санхүүгийн байгууллага өөр журмаар таньж тогтоосон хувь хүн, хуулийн этгээдээс гадна эдгээр санхүүгийн байгууллагаас хатуу хяналт явуулах ёстой тодорхой хувь хүн, хуулийн этгээдийн талаар санхүүгийн эдгээр байгууллагад оролцогч өөр улсын хүсэлтээр эсхүл өөрийн санаачлагаар зохих тохиолдолд мэдэгдэнэ.

**3. Танай улсад уг зүйл заалтыг мөрддөг үү?**

**ХАРИУЛТ:** Тийм

**4. Уг зүйлийг хэрэгжүүлэх тал дээр танай улс ямар арга хэмжээ авч байгааг (эсвэл төлөвлөж байгаа арга хэмжээг) тодорхойлно уу. (иш татан, нэгтгэн дүгнэх)**

**ХАРИУЛТ:**

- Монголын хөрөнгийн бирж дээр арилжаанд оролцож буй гадаад улсаас авсан энгийн иргэн болон хуулийн этгээдийн нэрс “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХК-д, мөн кастодианы тусгай зөвшөөрөл авсан банкуудад давхар бүртгэлтэй байдаг.

Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журмын 7.7.3.-т зааснаар “НҮБ-ын тогтоолоор террорист гэж зарлагдсан байгууллага, этгээдийн нэрсийн жагсаалтыг гаргах, мэдээлэх, тэдгээрийн гүйлгээг түдгэлзүүлэх тухай журам”-ын дагуу уг жагсаалтад нэр нь орсон этгээдэд үйлчилгээ үзүүлэх, хамтран ажиллахыг хориглосон.

Хорооноос тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-аас үйлчилгээ авсан гадаадын иргэн болон хуулийн этгээдийн нэрс нь 20 сая төгрөгөөс дээш буюу сэжигтэй гүйлгээ гэж үзэхээр бол энгийн иргэн болон хуулийн этгээдийн холбогдох данс хаагдсанаас эсвэл гэрээ дуусгавар болсноос хойш 5 жилийн хугацаатай хадгалагдаж байхаар журамд тусгасан.

3. Тухайн хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар жишээ татна уу.

### **ХАРИУЛТ:**

Зохицуулалтын салбарын хуулиас гадна Хорооноос тэдгээр хуулиудад нийцүүлэн боловсруулсан зохицуулалтын журамд холбогдох хяналт зохицуулалтыг нарийвчлан зохицуулсан бөгөөд хууль, журмаар тогтоосон нөхцөл шаардлагыг хангаж байгаа эсэхэд зайнаас болон газар дээрх хяналт шалгалтыг тогтмол хийж байна.

Салбарын зохицуулалтын байгууллагуудад эрсдэлийн үнэлгээг улирал бүр хийж байна. Мөн зохицуулалтын салбаруудын улирал, жилийн тоон мэдээллүүдийг нэгтгэн, зах зээлийн болон салбарын тойм, дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж, УИХ болон бусад төрийн байгууллагуудад тогтмол хүргүүлдэг.

Хороо нь мөнгө угаахтай тэмцдэг бүс нутгийн, бүс хоорондын болон 2012 онд ФАТФ-аас олон улсын стандарт болгон гаргасан МУТС-ээс сэргийлэх 40 зөвлөмжид үндэслэн 2013 онд шинэчлэн батлагдсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, мөн бусад улс, орны хяналт, шалгалтын байгууллагуудтай хоёр талт хамтын ажиллагааг хэрэгжүүлэх санамж бичгийн хүрээнд тодорхой мэдээллийг тухайн байгууллагаас авах боломжтой боловч өнөөдрийн байдлаар Үнэт цаасны зохицуулалтын газрын зүгээс мэдээлэл авч байгаагүй байна.

Эрх бүхий удирдлагын зүгээс санхүүгийн байгууллагууд зохих тохиолдолд бусад хуулийн этгээд байгууллагуудад хатуу хяналт тавих шаардлагатай данс эзэмшигч энгийн иргэн, хуулийн этгээдийн биеийн байцаалтыг мэдэгдсэн сонордуулга, зөвлөмж гаргаагүй. Харин өндөр эрсдэл бүхий хувь хүн, даатгалын зах зээл дээрх оролцогчийн талаарх мэдээллийг зохицуулсан журам гаргахаар ажиллаж байна

### **52-р зүйлийн 3-р бүлэг**

Энэ зүйлийн 2 дахь хэсгийн (а) дэд хэсгийн хүрээнд, энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан хүмүүст хамаарах данс, гүйлгээний зохистой бүртгэлийг санхүүгийн байгууллагууд нь зохих хугацаанд хөтөлж байх явдлыг хангах арга хэмжээг оролцогч улс бүр авч хэрэгжүүлэх бөгөөд энэ бүртгэлд наад зах нь харилцагчийн, мөн боломжтой бол жинхэнэ эзэмшигч хэн болох тухай мэдээллийг агуулбал зүйтэй.

**1. Танай улсад уг зүйл заалтыг мөрддөг үү? -Тийм**

**2 АВИЛГАЛЫН ЭСРЭГ НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН КОНВЕНЦ-ЫН уг Зүйлийг хэрэгжүүлэх тал дээр танай улс ямар арга хэмжээ авч байгааг (эсвэл төлөвлөж байгаа арга хэмжээг) тодорхойлно уу. (иш татан, нэгтгэн дүгнэх)**

**Хариулт:**



Зохицуулалтын салбар бүрт нягтлан бодох бүртгэлийн журмуудыг баталсан бөгөөд санхүүгийн тайлан мэдээг улирал бүр тогтмол Хороонд ирүүлдэг. Мөн гадаад валютын арилжаа, төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, итгэлцлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудын хувьд тухайн үйл ажиллагааны талаарх мэдээг сар бүр Хороонд ирүүлэх үүргийг хүлээдэг. Эдгээр асуудлыг тус тус салбарын зохицуулалтын журмуудаар зохицуулсан.

ББСБ, ХЗХ-дын харилцагчийн сэжигтэй гүйлгээ гэж үзэх хангалттай үндэслэл байгаа бол эсхүл хууль тогтоомжид хориглоогүй мэдээлэл өгөхөөс илт татгалзсан бол 24 цагийн дотор Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлж байхаар заасан бөгөөд гүйлгээтэй холбоотой мэдээлэл, бичиг баримтуудыг мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчийн нэр хаягийг тогтоосон баримт, данс бүртгэлийн болон бичиг хэргийн харилцааны талаарх мэдээллийг холбогдох данс хаагдсанаас эсвэл гэрээ дуусгавар болсноос хойш 5 жилээс доошгүй хугацаанд хадгалж байх журамтай. Хорооны 2008 оны 07 дугаар тогтоолоор Банк бус санхүүгийн байгууллагын хувийн хэрэг хөтлөх зааврыг батлан мөрдүүлж байна.

### **3 Тухайн хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар жишээ татна уу.**

#### **Хариулт:**

Гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ-дын хувьд 1 сараас доошгүй хугацаагаар мэдээллийг хадгалах багтаамжтай камерыг байрлуулах, харилцагчид баримт хэвлэж өгөх, 20,0 сая төгрөг, түүнтэй тэнцэх хэмжээний валют солих тохиолдолд МБ-ны СМА-нд 7 хоног мэдээлэх гэх мэт нарийвчилсан зохицуулалттай бөгөөд мэдээллийг тогтмол сар бүр хүлээн авдаг. Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаа эрхлэх ББСБ-дын хувьд мөн адил 20,0 сая төгрөг, түүнтэй тэнцэх хэмжээний валют солих тохиолдолд МБ-ны СМА-нд 7 хоног мэдээлэх үүрэгтэй бөгөөд тухайн хуулийн хэрэгжилтэд хяналт тавих этгээд нь Монголбанкинд мэдээллийг тогтмол өгч байх үүргийг хүлээсэн

Хороо нь мөнгө угаахтай тэмцдэг бүс нутгийн, бүс хоорондын болон 2012 онд ФАТФ-аас олон улсын стандарт болгон гаргасан МУТС-ээс сэргийлэх 40 зөвлөмжид үндэслэн 2013 онд шинэчлэн батлагдсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, мөн бусад улс, орны хяналт, шалгалтын байгууллагуудтай хоёр талт хамтын ажиллагааг хэрэгжүүлэх санамж бичгийн хүрээнд тодорхой мэдээллийг тухайн байгууллагаас авах боломжтой боловч өнөөдрийн байдлаар Бичил санхүүгийн зохицуулалтын газрын зүгээс мэдээлэл авч байгаагүй байна.

Жич: СЗХ-ны frc@mn цахим хаягийн “Хууль, эрх зүйн актууд” цэсэнд дээрх хууль тогтоомжууд байгаа болно.

Цахимд хуудсанд байхгүй 4 санамж бичгийг хавсралтаар цаасаар хүргүүлэв. /тайлангийн 6 дугаар хуудсанд дурдсан/

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО